



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/97

Мандалговь

“Эм Эс Эс Эйч” ХХК-тай гэрээ байгуулах
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/180 тоот захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Гамшгийн эрсдлийг бууруулах нөөц” ажлын батлагдсан зардлаас Коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор хамгаалах хувцас хэрэгсэл хүлээн авах ажлыг “Эм Эс Эс Эйч” ХХК-тай 58,870,000 (тавин найман сая найман зуун далан мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Гэрээнд заасан хугацаанд Коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор хамгаалах хувцас хэрэгсэл хүлээлгэж өгөхийг “Эм Эс Эс Эйч” ХХК-ны захирал (Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн (М.Болор-Эрдэнэ), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Л. Доржбат* Л.ДОРЖБАТ



486210426